

Танд **СҮРЬЕЭ ӨВЧНИЙ СОРИЛ** (эсвэл арьсан дор туберкулины тариа) хийх болсон. Энэ сорил нь сүрьеений нянгийн эсрэг таны биеийн өөрийгөө хамгаалах чадварыг үнэлэх зорилготой хийгддэг сорил бөгөөд Сүрьеэний Нуугдмал Халдвартай (СНХ) эсэхийг илрүүлэх буюу үүнээс сэргийлэх эмчилгээ танд шаардагдаж байгаа эсэхийг тогтоож шийдэх зорилготой юм.

Үүнийг уншиж тус сорилын хариуг буруу, өөрчлөлттэй гаргахгүйн тулд хэрэгцээтэй болон мөрдөх шаардлагатай хэдэн төрлийн зөвлөгөөг бид дор тайлбарлаж байна.

Таны мэдээлэлд :

Тус сорилын хариу нь тариа хийснээс 72 цагийн дараа гардаг, эхний 48 цагт тариа хийсэн хэсэгт арьсны өөрчлөлт, тариа хийсэн хэсгийн хэмжээнд өөрчлөлт гарсан тохиолдолд санаа зовох, шаналах шаардлагагүй. Сорилын хариуг мэргэжлийн эмч эсвэл мэргэжлийн сувилагч тодорхойлон гаргадаг.

Сүрьеэгийн сорил нь халууруулдаггүй, ядраадаггүй. Харин арьсанд загатнах, улайх зэргийн өөрчлөлт үүсэж болно.

Мөрдөх зөвлөгөө :

- Тариа хийснээс 30 минутын дараа боолтыг авна уу.
- Тариа хийсэн хэсгийг маажиж болохгүй. Загатнасан тохиолдолд гараа хүйтэн усаар зайлна уу.
- Тариа хийсэн хэсэгт юу ч хүргэж, ямар нэгэн тос түрхэж болохгүй. (жишээлбэл, кортикоид агуулсан тос, үрэвлийн эсрэг тос, далдлах оролдлого гэх мэт ...)

СҮРЬЭГИЙН ШИНЖ ТЭМДГҮҮД

Гол шинж тэмдгүүд :

- Шөнийн хөлрөлт
- Халууралт
- Ерөнхий биеийн өөрчлөлтүүд :
 - ✓ жин алдах
 - ✓ хоолонд дургүй болох
 - ✓ маш ихээр ядрах

Уушигнаас шинж тэмдэг :

- Цусан цэр гарах
- Эмчилгээ хийгдсэн ч гэсэн 2 -оос 3 долоо хоногийн туршид ханиалгах
- Цээжээр өвдөх

Энэ зэргийн олон төрлийн шинж тэмдгүүд сүрьеэ өвчнийг илчилсэн шинжүүд болж өгдөг.

Хэрэв танд энэхүү шинж тэмдгүүд илэрч байвал та өөрийнхөө эмчлэгч эмчтэй холбоо барих эсвэл CLAT байгууллагатай холбоо барина уу.

Биеийн эсэргүүцэл бууруулах эмчилгээ, жишээлбэл, удаан үргэлжлэлийн гормон кортикостероидон эмчилгээ (хоногт 10 мг-аас илүү), мөн TNF эсрэг (Enbrel®, Rémicade®, Humira® ...) зэргийн эмчилгээ нь сүрьеэ өвчинд өртөх эрсдэлийг ихэсгэдэг байна.

Маенны Сүрьеэ Өвчний Эсрэг Тэмцэх Төв (CLAT)

Лавал хотын Төв Эмнэлэг

33 От Рошер гудамж

53000 ЛАВАЛ

☎ 02 43 66 50 55

✉ clat53@chlaval.fr

